

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ


/2015 оны 11 сарын 04-ны өдрийн байдлаар/

МАХНЫ ҮНЭ


2015 оны 11 сарын 04-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар 1 кг хонины мах дунджаар 4167 төгрөгөөр, ямааны мах 3667, адууны мах 3667 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины махны үнэ 48.0 хувиар, ямааны махны үнэ 54.5 хувиар, адууны махны үнэ 64.0 хувиар тус тус буурчээ. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад малын махны үнэ дунджаар 266-333 төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг1.Махны үнэ 2015 оны 10-11 сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 11 сарын 04-ны өдрийн байдлаар малын шингэн сүү 3000 төгрөг, цагаан будааны үнэ дунджаар 2300 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 1933 төгрөг, алтан тариа 1-р гурил 1217 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад элсэн чихрийн үнэ 3.5 хувиар, цагаан будааны үнэ 4.3 хувиар тус тус буурч, алтан тариан гурил 4.4 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад хүнсний барааны үнэ тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 10-11 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 11 сарын 04-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үе болон долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Автобензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 10-11 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 11 сарын 04-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны цагаан ноолуурын үнэ 48000 төгрөгөөр худалдаалагдаж байгаа нь өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Зураг 4.Ноолуурын үнэ, 2015 он 10-11 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.